

Хөрөнгийн зах зээлийн талаар авах
зарим арга хэмжээний тухай

Хорооноос 2007 оныг “Хөрөнгийн зах зээлийн хөгжлийн жил” болгон зарлаж, тавьсан зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компаниудад хийсэн үзлэгийн нэгдсэн тайлан, “Хөрөнгийн бирж” ХК, Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-ийн жилийн эцсийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг хэлэлцээд ТЭМДЭГЛЭХ НЬ:

Хорооны даргын баталсан удирдамжийн дагуу ажлын хэсгүүд байгуулж, нийт 21 аймаг, Улаанбаатар хотын 8 дүүрэг, зарим сумдад хийсэн хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компанийн үзлэгт 284 ХК хамрагдсанаас 137 компанийн үйл ажиллагаа хэвийн, 47 компанийн үйл ажиллагаа дунд зэрэг, 101 компанийн үйл ажиллагаа нь зогссон, үүнээс 16 компанийн бүх өмч хөрөнгө үрэгдсэн байна. Хувьцаат компаниудад компанийн зохистой удирдлагын зарчмыг хэрэгжүүлдэггүй, хурлаа хийдэггүй, мэдээллийг нийтэд хүргэдэггүй, нягтлан бодох бүртгэл, аудитын үйл ажиллагаа хангалтгүй, том хувьцаа эзэмшигч буюу удирдлагын зүгээс компанийн өмч хөрөнгийг үрэн таран хийдэг, их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх талаархи Компанийн тухай хуульд заасан журмыг хэрэгжүүлдэггүй, үнэт цаасны мэргэжлийн оролцогчид харилцагчдын мөнгө болон хувьцааг зөвшөөрөлгүйгээр худалдсан буюу завшсан, эрсдэлд оруулж алдсан зэрэг ноцтой зөрчил, гэмт хэрэг 1990-ээд оны сүүлийн хагасаас 2002 он хүртэл хавтгайрсан, олон иргэд төвлөрсөн хадгаламжид дансаа нээлгээгүй, хувьчлалаар авсан хувьцаагаа баталгаажуулах, үр ашигтайгаар удирдах талаар огт санаа тавиагүй, хувьцаа эзэмшигчийн зүгээс тавих хяналт, эрхээ хэрэгжүүлэх, хамгаалах арга хэмжээ авдаггүй зэрэг нийтлэг зөрчил илэрсэн байна. Үнэт цаасны зохицуулагч байгууллагын зүгээс авч хэрэгжүүлсэн арга хэмжээ зохих шаардлагын түвшинд хүрээгүй, хууль зөрчсөн хувьцаат компанийн удирдлага, аудитор, мэргэжлийн оролцогчдын эсрэг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалан шүүхэд хандах зэрэг зарим эрх мэдлийг хуулиар олгоогүйгээс хөөн хэлэлцэх хугацааны дотор гэм буруутай этгээдэд хууль зүйн дагуу зохих хариуцлага тооцож чадаагүй байна. Өмч хувьчлалын хуулийн дагуу бүх нийтээр үнэт цаас өмчлөгч болсон боловч учрыг ойлгосон хэсэг бүлэг нь зах зээлийн боломж бүхнийг ашиглаж чадсан байхад санхүүгийн боловсрол багатай, мэдээллээс тасарсан олон иргэд өөрт олдсон боломжоо ашиглаж эрхээ хэрэгжүүлж, өмчлөгчийн хувьд үүргээ биелүүлдэггүйгээс нийгмийн ихээхэн баялаг эдийн засгийн ямар ч эргэлтэд орохгүй, үнэт цаасны бүртгэл, хадгалалтын зардлыг жил ирэх бүр нэмэгдүүлж байна.

Сүүлийн жилүүдэд хөрөнгийн зах зээл идэвхжиж, 2007 онд 102.6 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн нь өмнөх оныхоос даруй 5.7 дахин, зах зээлийн

үнэлгээ 5.4 дахин, ТОП-20 индекс 5.1 дахин өсч, зах зээлийн үнэлгээний ДНБ-д эзлэх хувь 2006 онд 5.2 хувь байсан бол өнгөрсөн онд 21.6 хувьд хүрч, 4.1 дахин өссөн байна. Үйлчилгээний чанарыг сайжруулах, мэдээллийн технологийг нэвтрүүлэх, хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэх талаар “МХБ” ХК, “ҮЦТТХТ” ХХК-ийн зүгээс тодорхой ажлууд хийсэн буюу хийж эхэлж байгаа боловч, өмч хувьчлалын үр дүнд бий болсон үнэт цаасны зах зээлийг цэгцлэх,

2

цэвэрлэх, дэлхий нийтийн нийтлэг жишгийн дагуу хөрөнгийн зах зээлийг сонгодог утгаар нь хөгжүүлэх бэлтгэлийг сайтар хангах шаардлагатай байна.

Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ НЬ:

НЭГ. Дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Ажлын алба /О.Ганбат/, Үнэт цаасны газар /Э.Ганбат/-т даалгасугай.

1. Үзлэгт хамрагдаагүй үлдсэн хувьцаат компаниудыг газар дээр нь болон орон нутаг дахь төлөөлөгчөөр дамжуулан зохих удирдамжийн дагуу үзлэгт хамруулах арга хэмжээг 2008 оны 1 дүгээр улиралд багтаан зохион байгуулж, дүнг Хороонд танилцуулах;

2. Үйл ажиллагаа нь зогссон, өмч хөрөнгө нь үрэгдсэн нэр бүхий 101 компанийн хувьцааг 2008 оны 3 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн Хөрөнгийн биржийн арилжаанд оруулахгүй байх арга хэмжээг улсын байцаагчийн эрх хэмжээний хүрээнд авч, энэ тухай олон нийтэд компанийн нэрээр нь даруй мэдээлж сурталчлах;

3. Компанийн болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд оруулах нэмэлт, өөрчлөлт, Хөрөнгө оруулалтын сангийн тухай, Хөрөнгө итгэмжлэн удирдах тухай хуулийн төслүүдийг холбогдох байгууллагатай хамтран 2008 онд багтаан боловсруулах;

4. Компанийн төв захиргаа оршин байгаа газраас өөр орон нутагт оршин сууж буй хувьцаа эзэмшигчдийн ногдол ашгийг зөвхөн “ҮЦТТХТ” ХХК-иар зуучлуулан тараах буюу дансанд нь байршуулдаг болгох чиглэлээр журам боловсруулж 3 дугаар сард багтаан Хорооны хуралдаанд оруулах;

5. Хөдөө орон нутгийн иргэдэд үзүүлэх хөрөнгийн зах зээлийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор банк, санхүүгийн байгууллага, шуудангийн болон хөдөлгөөнт холбооны компаниудын хосолсон үйлчилгээг нэвтрүүлэх боломжийг “МХБ” ХК, “ҮЦТТХТ” ХХК, Арилжаа эрхлэгчдийн холбоо, холбогдох бусад байгууллагуудтай хамтран судалж, гарсан санал санаачлагыг дэмжих талаар асуудал боловсруулж, 2008 оны 5 дугаар сард багтаан Хороонд танилцуулах;

6. ХК-ийн үл хөдлөх хөрөнгийн бүртгэлд өөрчлөлт оруулах тохиолдолд Хорооноос мэдээлэл авч байгаа тогтсон практикийг хөдөө орон нутагт нэвтрүүлэх талаар Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газарт асуудал тавьж шийдвэрлүүлэх;

7. Хороонд бүртгэлтэй төрийн болон орон нутгийн өмчит буюу төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой ХК-иудын хувьчлалын талаарх мэдээллийг цаг алдалгүй Хороонд ирүүлж байх, хувьчлагдсан үед нь “ҮЦТТХТ” ХХК-д мэдэгдэж, хувьчлан авсан этгээдийн өмчлөх эрхийг баталгаажуулах гүйлгээг тухай бүр хийлгэж хэвшүүлэх зэрэг асуудлаар зохих журам тогтоон Төрийн өмчийн хороо, Аймаг, нийслэлийн Засаг дарга нарт мэдээлэл хүргэж хамтран ажиллах;

8. Дансаа нээлгээгүй, эсхүл нээлгэсэн боловч үлдэгдлээ шалгаж баталгаажуулаагүй хувьцаа эзэмшигчдийн талаар судалгаа хийж, үлдэгдэл хөрөнгийг хөрөнгө оруулалтын сангийн хувьцаанд шилжүүлэх замаар хөрөнгө оруулалтын сан байгуулж, тухайн үеийн үнэ цэнийг алдагдуулахгүйгээр хөрөнгө оруулалтын менежмент хийж, уг хөрөнгийг эргэлтэд оруулах хууль эрх зүйн боломжийг судалж 2008 оны 7 дугаар сард багтаан саналаа Хороонд танилцуулах.

3

9. “ҮЦТТХТ” ХХК-тай хамтран харилцагчдын мөнгөн хөрөнгийг байршуулах арилжааны банкинд тавигдах шаардлага, нэг банкинд байршуулж болох мөнгөний зохистой харьцаа, эрсдлийн үнэлгээний жишиг горим, банкийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, Хороог мэдээллээр хангах талаар өөрийн орны нөхцөл байдал, олон улсын туршлага, зарчмыг судлан саналаа боловсруулж 2008 оны 2 дугаар улиралд багтаан Хороонд танилцуулах;

10. Үнэт цаасны арилжаанд тавих хяналтыг шуурхай, үр нөлөөтэй зохион байгуулах талаар саналаа боловсруулж 2008 оны 4 дүгээр сард багтаан Хороонд танилцуулах.

ХОЁР. “Хөрөнгийн бирж” ХК / Р.Содхүү/-д ДААЛГАХ нь:

1. Хууль тогтоомж удаа дараа зөрчдөг, үйл ажиллагаа нь зогссон, өмч хөрөнгө нь үрэгдсэн, бүртгэлийн шаардлага хангахгүй болсон хувьцаат компанийг бүртгэлээс хасах болон хөрөнгийн биржийн бүртгэлд байгаа хувьцаат компанийн хувьцааны арилжааг тодорхой ангиллын дагуу ялган арилжих горимыг нэвтрүүлэх ажлыг 2008 онд багтаан зохион байгуулах нарийвчилсан төлөвлөгөөг Хорооны 3 дугаар сарын хуралдаанд танилцуулж хэрэгжүүлэх;

2. Хувьцаат компанийн үйл ажиллагаа, байгуулсан гэрээний хэрэгжилтэд тавьж буй хяналтын тогтолцоог Компанийн засаглалын кодекст дурдсан зарчмын дагуу судалж боловсронгуй болгон, хувьцаат компанийн тайлан баланс, нийтэд

мэдээлбэл зохих мэдээллийг өөрийн вэб хуудас болон бусад боломжтой хэрэгслээр нийтэд шуурхай хүргэх арга хэмжээ авах;

3. Бүртгэлийн шалгуурыг нэгээс дээш ангилалтайгаар шинэчлэн тогтоож, олон нийтийг хохироож болох эд хөрөнгө нь үрэгдсэн, үйл ажиллагаа нь зогссон хувьцаат компанийн баталгаагүй болсон хувьцааны арилжааг зогсоох, бүртгэлээс хасах чиглэлээр тус Хорооны Үнэт цаасны газар, харьяалах брокер, дилерийн компани болон бусад холбогдох байгууллагатай хамтран нэгдсэн арга хэмжээг 2008 оны 2-3 дугаар улиралд зохион байгуулж, дүнг 4 дүгээр улирлын эхний сард багтаан илтгэх;

4. Мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаанд тавих газар дээрх хяналтыг сайжруулж, захиалгын гэрээг гүйцэтгэж буй байдал, зөвшөөрөлгүй үнэт цаас арилжаанд оруулж буй нөхцөл байдлыг арилган, хариуцлагын тогтолцоог чангатгах, шат дараалал бүхий хариуцлагын тогтолцоог төлөвшүүлж, удаа дараа зөрчил гаргасан компанийн суудлын эрхийг хасах, зах зээлд үйл ажиллагаа явуулах боломжийг хязгаарлах хүртэл шаардлагатай бүх зохицуулалтыг бий болгож, чанд мөрдөн ажиллах;

5. Үнэт цаасны арилжааны горимд дүн шинжилгээ хийж үнэт цаасны үнийг цөөн тооны хувьцааны арилжаанд үндэслэн өөрчлөх замаар бусад хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хохироох, арилжааны явцад захиалга шивэгддэг, технологийн болон шивэлтийн хурдаас хамаарч арилжааны үр дүн тодорхойлогддог зэрэг зохисгүй практикийг таслан зогсоох арга зам, үнэт цаасыг анх удаа нийтэд санал болгон арилжих ажиллагааг өнөөгийн аргачлалаар зохион байгуулах нь зохистой эсэх асуудлыг сайтар судалж, саналаа 2008 оны 2 дугаар улиралд багтаан танилцуулах;

6. Үнэт цаасны зах зээлийн орчин үеийн шаардлагад нийцсэн техник, программ хангамжийн системийг бүрдүүлэн мэргэжлийн чадварлаг боловсон хүчнээр хангаж ажиллах, ялангуяа санхүү, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр дүн шинжилгээг өндөр түвшинд хийх чадвар бүхий багийг бүрдүүлэх асуудлыг анхаарч ажиллах.

ГУРАВ. “ҮЦТТТХТ” ХХК /Т.Гандулам/-д ДААЛГАХ нь:

4

1. Засгийн газрын шийдвэрийн дагуу хувьцаа эзэмшигчдэд олгох ёстой ногдол ашгийн болон хувьцаа худалдсан орлогын тараагдаагүй мөнгөний үлдэгдлийг орон нутагт тарааж дуусгах талаар тодорхой арга хэмжээ авч, тараагдаагүй үлдсэн мөнгө, урьд оны ногдол ашгийг харилцагчдын дансанд байршуулж, биелэлтийг 2008 оны 4 дүгээр улиралд багтаан Хороонд танилцуулах;

2. “ҮЦТТТХТ” ХХК-ийн үйл ажиллагаанд “Харилцагчийн дэвтэр”-ийг нэвтрүүлэх чиглэлээр судалж, саналаа Хороонд оруулах;

3. Үйл ажиллагаандаа нэвтрүүлж байгаа мэдээллийн технологийн ололтыг улам бататгаж, аппаратаа мэргэжлийн чадварлаг боловсон хүчнээр хангаж, байгууллагын эрсдлийн удирдлагыг сайжруулах арга хэмжээ авч, дүнг Хороонд танилцуулах.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ